



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/370

Чингис хот

Голомтын халдваргүйтгэлийн ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.12 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт болон малаас хүнд халдварладаг зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шүлхий, хонины цэцэг, боом, галзуу өвчний голомтуудыг ариутгаж, халдваргүйтгэх ажлыг 2021 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Мал, амьтны гоц халдварт болон малаас хүнд халдварладаг зооноз өвчний голомтуудыг халдваргүйтгэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Голомтын халдваргүйтгэлд шаардагдах эмийн бодис, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, заавар арга зүйгээр хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т хариуцуулж, шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх сангаас шийдвэрлэж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011846

08 Аймгийн Засаг даргын 2021 оны  
 дугаар сарын 06 өдрийн А/370  
 дугаар захирамжийн хавсралт

2021 ОНД ШҮЛХИЙ, ХОНИНЫ ЦЭЦЭГ, БООМ, ГАЛЗУУ ӨВЧНИЙ ГОЛОМТУУДЫГ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Сумын нэр	Халдваргүйтгэх голомтын тоо					Аймгаас сум, сумаас сум хооронд явах км	Сумаас голомт хүртэлх зай /км/	Нийт км	Голомт халдваргүйтгэхэд зарцуулах шатахуун						Нийт дүн
		Шүлхий	Хонины цэцэг	Боом	Галзуу	Бүгд				Автомашинд дизель түлш /литр/			Мотор ажиллуулахад А-80 /литр/			
										Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Бүгд үнэ	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Бүгд үнэ	
1	Баянхутаг			9		9	22	350	372	2600	74	193440	2120	9	19080	212520
2	Галшар	1			3	4	138	210	348	2500	70	174000	2990	4	11960	185960
3	Дархан	1			2	3	100	196	296	2650	59	156880	2240	3	6720	163600
4	Баянмөнх				2	2	45	100	145	2650	29	76850	2240	2	4480	81330
5	Дэлгэрхаан			17		17	65	277	342	2500	68	171000	2190	17	37230	208230
6	Жаргалтхаан			6	5	11	70	411	481	2480	96	238576	2120	11	23320	261896
7	Цэнхэрмандал			1		1	50	60	110	2500	22	55000	2120	1	2120	57120
8	Өмнөдэлгэр			19		19	110	413	523	2550	105	266730	2120	19	40280	307010
9	Биндэр			15		15	130	377	507	2670	101	270738	2190	15	32850	303588
10	Баян-Адрага			3		3	45	204	249	2450	50	122010	2210	3	6630	128640
11	Норовлин		1	5	1	7	80	240	320	2550	64	163200	2210	7	15470	178670
12	Батноров				1	1	100	22	122	2390	24	58316	2190	1	2190	60506
13	Баян-Овоо			2	2	4	62	250	312	2520	62	157248	2150	4	8600	165848
14	Мөрөн			2	5	7	165	256	421	2300	84	193660	2120	7	14840	208500
15	Хэрлэн	1		1	1	3	30	175	205	2400	41	98400	2120	3	6360	104760
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>1</b>	<b>80</b>	<b>22</b>	<b>106</b>	<b>1212</b>	<b>3541</b>	<b>4753</b>		<b>951</b>	<b>2396048</b>		<b>106</b>	<b>232130</b>	<b>2628178</b>